



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.03.15 № 660

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Ч.РЭГЗМАА ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Аудитын гол асуудал**



Тайлант онд төсвийг зориулалтын бусаар үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан 55,303.8 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан контрактын гэрээний холбогдох эрх зүйн акттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2020 оны  
санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2021/29/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2021 он

Эвиденсе аудит ХХК захирал: С.Бадамгарав

Утас: 99057121

Цахим хаяг: [info@evidenceaudit.mn](mailto:info@evidenceaudit.mn)

Аудитор: Б. Пушкин

Утас: 95047121

Цахим хаяг: [pushkin@evidenceaudit.mn](mailto:pushkin@evidenceaudit.mn)

Аудитор: Д.Шүрэнцэцэг

Утас: 70007121

Цахим хаяг: [shurentsetseg@evidenceaudit.mn](mailto:shurentsetseg@evidenceaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТӨА	Татвар төлөхийн өмнөх ашиг

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан .....	9
3.Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	12
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа .....	13
3.8. Шилэн дансны мэдээлэл .....	14
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.10. Аудитын илрүүлэлт .....	14
Залруулсан алдаа .....	
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	83,032,018.41	402,936,098.99
1.1.02	Дансны авлага	1,073,775,269.98	749,140,395.98
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	15,736,867.06
1.1.04	Бусад авлага	2,070,000.00	129,409.00
1.1.06	Бараа материал	34,418,853.64	45,268,293.23
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,193,296,142.03	1,213,211,064.26
1.2.01	Үндсэн хөрөнгө	93,194,419.61	288,606,758.37
1.2.02	Биет бус хөрөнгө	1,065,666.79	4,580,066.83
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	94,260,086.40	293,186,825.20
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,287,556,228.43</b>	<b>1,506,397,889.46</b>
2.1.1.01	Дансны өглөг	52,577,000.00	265,117,000.00
2.1.1.03	Татварын өр	99,576,375.07	0.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	9,541,645.24	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	9,548,607.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	161,695,020.31	274,665,607.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	161,695,020.31	274,665,607.00
2.3.01	Өмч: - төрийн	161,153,013.31	161,153,013.31
2.3.09	Хуримтлагдсан ашиг	964,708,194.81	1,070,579,269.15
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	64,117,122.68
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	964,708,194.81	1,006,462,146.47
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,125,861,208.12	1,231,732,282.46
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,287,556,228.43</b>	<b>1,506,397,889.46</b>



## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/ 2020 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,234,043,050.93
02	Борлуулалтын өртөг	1,443,485,606.97
03	Нийт ашиг( алдагдал)	790,557,443.96
04	Түрээсийн орлого	0.00
05	Хүүгийн орлого	897,535.42
06	Ногдол ашгийн орлого	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00
08	Бусад орлого	440,133.10
08.1	Орлогын дүн	1,337,668.52
09	Борлуулалт, маркетингийн зардал	130,474,270.88
10	Ерөнхий ба удирдлагын зардал	583,855,229.48
11	Санхүүгийн зардал	0.00
12	Бусад зардал	0.00
12.1	Зардлын дүн	714,329,500.36
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00
17.1	Олз, гарзын дүн	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	77,565,612.12
19	Орлогын татварын зардал	13,448,489.44
20	Татварын дараах ашиг (алдагдал)	64,117,122.68
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	64,117,122.68
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00
24	Орлогын нийт дүн	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
				Нийт дүн
01	2018 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	964,708,194.81	1,125,861,208.12
09	2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	964,708,194.81	1,125,861,208.12
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	41,753,951.66	41,753,951.66
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	64,117,122.68	64,117,122.68
17	2020 оны 12 сарын 31-р үлдэгдэл	161,153,013.31	1,070,579,269.15	1,231,732,282.46



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/ 2020 оны 12-р сарын 31
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,859,917,164.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,462,486,545.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,635,895.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	615,267,800.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	771,526,924.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,298,210,668.84
1.2.1	Ажиллагчдад төлсөн	655,928,617.41
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	240,036,224.05
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	28,221,097.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	53,924,660.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,757,200.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	89,753.55
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	353,604,895.37
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	517,612.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	945,130,609.46
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	561,706,495.16
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	897,535.42
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	897,535.42
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	242,699,950.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	242,699,950.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-241,802,414.58
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	319,904,080.58
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,032,018.41
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	402,936,098.99



## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 оны		/төгрөгөөр/	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.1	Борлуулалтын орлого	1,058,335.0	1,889,628.8	1,620,112.90	(269,515.9)	(0.14)
1.2	Нийслэлийн төсвөөс	-	615,267.8	615,267.8	-	-
1	Нийт орлогын дүн	1,058,335.0	2,504,896.6	2,235,380.7	(269,515.9)	(0.11)
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	357,562.1	566,888.7	1,443,485.6	876,596.9	1.55
2.2	Цалин, нэмэгдэл	534,747.9	1,121,073.1	0	(1,121,073.1)	(1.00)
2.3	НДШ	68,681.2	151,344.9	240,036.22	88,691.3	0.59
2.4	Түрээс ашиглалт	45,049.5	142,064.5	53,924.7	(88,139.8)	(0.62)
2.5	Албан томилолтын зардал	8,634.4	50,000.0	-	(50,000.0)	(1.00)
2.6	Элэгдлийн зардал	32,439.9	43,033.2	-	(43,033.2)	(1.00)
2.7	Түүхий эд материалын зардал	54,816.0	51,726.8	-	(51,726.8)	(1.00)
2.8	Зар сурталчилгааны зардал	2,000.0	4,000.0	-	(4,000.0)	(1.00)
2.9	Сургалтын зардал	13,202.4	35,000.0	-	(35,000.0)	(1.00)
2.10	Эрдэм шинжилгээ	12,990.0	38,000.0	-	(38,000.0)	(1.00)
2.11	Шуудан холбооны зардал	10,066.7	20,000.0	-	(20,000.0)	(1.00)
2.12	Шатахууны зардал	16,469.0	25,000.0	20,757.2	(4,242.8)	(0.17)
2.13	Засварын зардал	10,150.0	43,000.0	-	(43,000.0)	(1.00)
2.14	УЗ-ын зардал	23,040.0	34,020.0	399,611.4	365,591.4	10.75
	Үйл ажиллагааны зардал	832,287.0	1,758,262.5	714,329.5	(1,043,933.0)	(0.59)
2.15	Үйл ажиллагааны бус зардал	45,125.5	147,554.8	-	(147,554.8)	(1.00)
2	Нийт зардал	1,234,974.6	2,472,706.0	2,157,815.1	(314,890.9)	(0.13)
3	ТТӨА	(176,639.6)	32,190.6	77,565.6	45,375.0	1.41
4	Татварын зардал	246.6	4,829.0	13,448.5	8,619.5	1.78
5	Цэвэр ашиг	(176,886.2)	27,361.6	64,117.1	36,755.5	1.34